



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

20 21 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 201

Даланзадгад сум


**Аймгийн “Ойн менежментийн мастер  
төлөвлөгөө-2030”-ыг батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-ыг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Р.Сэддорж)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

461200236

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын  
22-ний өдрийн 201 дүгээр тогтоолын хавсралт



## **ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ-2030**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Өмнөговь аймаг нь Монгол улсын өмнөд цэгт байрлан, 165 мянган хавтгай дөрвөлжин километр өргөн удам нутаг дэвсгэртэй, 15 суманд 6546 айл өрх, 70371 хүн амтай.

Өмнөговь аймаг 13 сумын нутаг дэвсгэрт 1,189,226 га талбайд байгалийн заган ой тархан ургадаг бөгөөд үүний 91.7 хувь нь болц гүйцсэн хөгшин ой эзэлдэг.

Сүүлийн 5 жилийн дунджаар агаарын хэм 3-5 градусаар нэмэгдэж, ган зудын давтамж ойртож байгаа тул байгалийн заган ойд сэргэн ургалтад туслах, загийн бортоготой тарьцаар ойжуулах, төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулах шаардлагатай байгаа нь аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-г боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх үндэслэл болно.

### **ХОЁР. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

Ойн менежментийн мастер төлөвлөгөөний зорилго нь Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Өмнөговь аймаг 70 сая мод, сөөг тарьж ургуулах хариуцлагын гэрээний хэрэгжилтийг хангахад оршино.

Ойн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, ойг хамгаалах нөхөн сэргээх, хомстол доройтлыг бууруулах, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн экосистемийг бий болгож, иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотой ойжуулалт хийх, ойн зурвас байгуулж агро ойн аж ахуйг хөгжүүлэх, байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжиж, ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмждэг зөв менежментийн тогтолцоог бий болгох зорилготой.

Ойн менежментийн мастер төлөвлөгөөний зорилгыг 6 зорилтын хүрээнд 39 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд:

#### **Нэгдүгээр зорилтын хүрээнд.**

**2.1. Удирдлага зохион байгуулалт, эрх зүйн баримт бичиг боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

2.1.1. Төрөөс баримтлах ойн бодлогыг орон нутгийн онцлогт уялдуулан боловсруулах

2.1.2. “Нэг тонн баялаг-Нэг мод” хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх

2.1.3. Мод тарьж, ургуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах журмыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах

2.1.4. Уст цэгийн тооллого, судалгааг үндэслэн хөв цөөрөм байгуулах газрыг сонгох, булаг шанд хашиж хамгаалах ажлыг төлөвлөх

2.1.5. Хөв цөөрөм байгуулсан газрыг түшиглэн ойн зурвас байгуулах

2.1.6. Цэвэрлэх байгууламжийг сайжруулж, дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

2.1.7. Саарал усыг ногоон байгууламж, ойн зурвас талбайн мод сөөгний усалгаанд ашиглах

2.1.8. Нөхөрлөл, мэргэжлийн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, хамтран ажиллах

2.1.9. 2023-2030 он хүртэл мод тарих, ойн зурвас байгуулах талбайг үе шаттай төлөвлөх, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулах

2.1.10. "Хашаандаа сайхан амьдрья" аяныг өрнүүлж, дэд бүтцээр хангах, ашигт ургамал тарихыг бодлогоор дэмжинэ

2.1.11. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их дээд, сургуулиудтай хамтран ажиллах

2.1.12. Гадаад хамтын ажиллагаа өргөжүүлэх

2.1.13. Говь+ус хөтөлбөрийг хэрэгжүүлж, Улаан нуур-Даланзадгад-Тавантолгой чиглэлийн ус дамжуулах байгууламжийн ТЭЗҮ болон Даланзадгад сумын шинэ цэвэрлэх байгууламжийн саарал усыг ойжуулалт газар тариаланд ашиглах ажлын зураг төсвийг боловсруулах

2.1.14. Баянзагийн таримал заган ойн зурвас талбайн менежментийг сайжруулах

**Хоёрдугаар зорилтын хүрээнд.**

**2.2. Үр болон тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.**

2.2.1. Байгалийн болон таримал ойн сангийн талбайгаас мод сөөгний үр, мөчир бэлтгэх, нөөц бий болгох

2.2.2. Орон нутгийн мод үржүүлгийн газруудыг дэмжих, шинээр байгуулах

2.2.3. Мод үржүүлгийн газрын үр, тарьц суулгацын мэдээг нэгтгэн мэдээллийн сан бий болгох, олон нийтэд мэдээлэх

**Гуравдугаар зорилтын хүрээнд.**

**2.3. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбай нэмэгдүүлэх, ойжуулалт, ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.**

2.3.1.Төв суурин газарт нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх

2.3.2. Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулах

2.3.3. Хамгаалалтын ойн зурвасыг байгуулах, агро ойн аж ахуйг хөгжүүлэх

2.3.4. Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах

2.3.5. Байгалийн болон таримал ойн зурвасууд, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид хортон шавьжийн судалгаа, тэмцлийн ажлыг зохион байгуулах

2.3.6. Ойжуулалт, ойн зурвас талбайн цаашдын арчилгаа хамгаалалт, хөгжүүлэлтэд иргэд, олон нийтийн сайн дурын бүлэг, хоршоолол, нөхөрлөлүүдийг бэлтгэх

## **Дөрөвдүгээр зорилтын хүрээнд.**

### **2.4. Дэвшилтэд технологи, техник багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийг бий болгох зорилтыг хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулах**

- 2.4.1. Ургамлын эд, эсийн өсгөврийн лаборатори байгуулах
- 2.4.2. Хөрсний дээжийн лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах
- 2.4.3. Бордооны үйлдвэр байгуулах
- 2.4.4. Бортогоны үйлдвэрийг байгуулах
- 2.4.5. Ногоон байгууламжийн худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлж усалгааны систем, холбогдох тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх, нэмэгдүүлэх
- 2.4.6. Олон наст модлог ургамлын хэрэглээг зогсоож, орлох түлшний үйлдвэрлэлийг байгуулж хэрэглээг эрчимжүүлнэ.
- 2.4.7. Усыг хэмнэлттэй ашиглах төлөвшилтийг бий болгож, дэвшилтэд технологийн усалгааны системийг нэвтрүүлэх

## **Тавдугаар зорилтын хүрээнд.**

### **2.5. Сургалт, сурталчилгаа зохион байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулах**

- 2.5.1. Мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах сургалтад хамрагдах
- 2.5.2. Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил, аргазүйгээр хангах сургалт зохион байгуулах
- 2.5.3. Сум дундын ойн ангийн ойжуулалтын сургалтын төвийг говийн бүсийн ойжуулалтын сургалтын төв болгож өргөжүүлэх
- 2.5.4. Туршлага судлах

## **Зургаадугаар зорилтын хүрээнд.**

### **2.5. Санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох**

- 2.6.1. Нэгдсэн сан байгуулах
- 2.6.2. Олон улсын болон орон нутгийн төсөв
- 2.6.3. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт
- 2.6.4. Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө
- 2.6.5. Бусад эх үүсвэр

## **ГУРАВ. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

3.1. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг 2022-2030 онд дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- Бэлтгэл ажил хангаж ажлыг эхлүүлэх 2022-2024 он
- Мод тарьж ургуулах, ойжуулах ажлыг зохион байгуулах 2025-2028 он
- Амьдралт, ургалт, өсөлтийг дэмжих, арчлах 2029-2030 он

**ДӨРӨВ. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР НӨЛӨӨ,  
БҮТЭЭГДЭХҮҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

4.1. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

4.1.1. Байгалийн заган ойн сангийн талбайн хэмжээ нэмэгдэж, ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь өснө.

4.1.2. Мэргэжлийн аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаа тогтвортой сайжирна.

4.1.3. Төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээ нэмэгдэнэ.

4.1.4. Хамгаалалтын зориулалттай ойн зурвасууд бий болж агро ойн аж ахуй хөгжинө.

4.1.5. Байгаль цаг уур, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах чадавх нэмэгдэнэ.

4.1.6. Мод үржүүлгийн газар, ойжуулалт, ойн зурвас байгуулах, агро ойн аж ахуйд суурилсан ажлын байрны тжэҮоо нэмэгдэж, амьжиргааны эдийн засгийн боломжууд бий болж, ажилгүйдлийн хувь буурна.

4.1.7. Орон нутагт шаардлагатай үйлдвэрлэл хөгжих боломж үүснэ.

4.2. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг дүгнэхдээ 2023-2030 оныг хүртэл хийгдсэн ажлын үр дүнгээр дүгнэнэ.

2021 оны жилийн эцсийн үзүүлэлт, ойн зохион байгуулалтын мэдээг суурь үзүүлэлт болгон ашиглана.

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин /2030 он/
1	Мод үржүүлгийн газруудыг нэмэгдүүлж, говь цөлийн бүсийн мод, сөөгийг үр болон мөчрөөр үржүүлэх	Тоо хэмжээ	7	15
2	Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулалт хийх	га	16	5200
3	Төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	га	314	80
4	Ойн зурвас талбай байгуулах	га	2553	65000

**ТАВ. ОЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ  
ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР**

5.1. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах эх үүсгэврээс санхүүжнэ.

- Нэгдсэн сан байгуулна
- Улсын болон орон нутгийн төсөв

- Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусалж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт
- Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө
- Банк, санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй зээл
- Бусад санхүүгийн эх үүсвэр

## ЗУРГАА. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөр, Өмнөговь аймгийн “Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах улсын хэмжээний болон орон нутгийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Ойн менежментийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төсөв, хөрөнгө оруулалт, зээл тусламжийн санхүүжилтийг судалж, нэмэгдүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

6.3. Ойн менежментийн мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутгийн түвшинд зохион байгуулах, иргэд аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжих, мод тарьж ургуулах ажилд бүх нийтийг хамруулах, уриалах, өрхийн болон жижиг, дунд мод үржүүлэг болон хөрс бордооны жижиг дунд үйлдвэрлэлийг нэвтрүүлж, ажлыг байрыг бий болгох чиг үүргийг бүх шатны Засаг дарга нар хариуцна.

6.4. Мод үржүүлгийн газар, ойн зурвас байгуулах, ойжуулалт хийх талбайг тухайн аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, талбай олгох асуудлыг харьяа сумын Засаг дарга нар хариуцна.

6.5. Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа, үр, тарьц суулгацын стандарт, чанарын асуудал болон бэлтгэх, нийлүүлэх ажлыг тухайн аж ахуйн нэгж аймгийн БОАЖГазар, СДОАнги хамтран хариуцна.

6.6. Иргэд, нөхөрлөл, сайн дурын зөвлөлүүд, хоршоо, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг мод тарих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход мэргэжил аргагүйгээр хангаж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аяла жуулчлалын газар, сум дундын ойн анги, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага, их дээд сургуулиудтай хамтран зохион байгуулна.

## ДОЛОО. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ХЭМЖЭЭ

7.1. Ойн менежментийн мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, сум дундын ойн анги, мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран жил бүр хийнэ.



7.2. Ойн менежментийн мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилт бүрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, сум дундын ойн анги хариуцан гүйцэтгэж, тайлангаа жил бүр аймгийн Засаг даргын зөвлөл, иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлнэ.

7.3. Орон нутгийн хэмжээд төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч нар хариуцан гүйцэтгэж, тайлангаа аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

7.4. Ойн менежментийн мастер төлөвлөгөөний явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн төлөвлөгөөнд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт өөрчлөлт, эрхзүйн зохицуулалт оруулж болно.

--oOo--

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОЙН МЕНЕЖМЕНТИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ-2030**

Д/Д	Хөтөлбөр (Хөтөлбөрийн нэр) хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин			Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				2022-2024	2025-2027	2028-2030		
<b>Зорилт 1: Удирдлага зохион байгуулалт, эрх зүйн баримт бичиг</b>								
1.1	Төрөөс баримтлах ойн бодлогыг орон нутгийн онцлолт уялдуулан боловсруулах	Бодлогын баримт бичиг, төлөвлөгөө	2018-2020 оны ойн менежментийн төлөвлөгөө	“Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030” –г боловсруулж, батлуулсан байна.			БОАЖЯ, АЗДТГ, БОАЖГ, СДОА	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт
1.2	“Нэг тонн баялаг-Нэг мод” хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Модны тоо	21376	60.0 сая			АЗДТГ, БОАЖГ	Уул уурхайн компаниуд
1.3	Мод тарьж, ургуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах журмыг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо	84	90	110	130	АЗДТГ, БОАЖГ,	Иргэд, нөхөрлөл ААН, байгууллагууд
1.4	Уст цэгийн тооллого, судалгааг үндэслэн хөв цөөрөм байгуулах газрыг сонгох, булаг шанд хашиж хамгаалах ажлыг төлөвлөх	Байгуулах хөв, цөөрөм болон хаших булаг шандын тоо	Булаг – 191 Хөв цөөрөм – 4	Булаг 15 Цөөрөм-3	Булаг 15 Цөөрөм-6	Булаг 15 Цөөрөм-8	АЗДТГ, БОАЖГ	Аж ахуйн нэгж байгууллагууд, сумд
1.5	Хөв цөөрөм байгуулсан газрыг түшиглэн ойн зурвас байгуулах	Хөв цөөрмийн тоо, ойн зурвасын талбайн хэмжээ	Хөв цөөрөм-4 Ойн зурвас талбай -	Хөв цөөрөм - Ойн зурвас талбай -	Хөв цөөрөм- Ойн зурвас талбай -	Хөв цөөрөм- Ойн зурвас талбай -	АЗДТГ, БОАЖГ, СДОА	Аж ахуйн нэгж байгууллагууд
1.6	Цэвэрлэх байгууламжийг сайжруулж, дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	Байгууламжийн тоо	15	15			АЗДТГ, БОАЖГ, Сумдын ЗДТГ	Сав газрын захиргаадүүд, Гүний ус ХХК
1.7	Саарал усыг ногоон байгууламж, ойн зурвас талбайн мод сөөгний усалгаанд ашиглах	Ашигласан усны хэмжээ м3 Ашиглах усны хувь	171.9 мянга 85%	95%			АЗДТГазар	БОАЖГ, СДОА, Сумд



1.8	Нөхөрлөл, мэргэжлийн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих, хамтран ажиллах	Ойн нөхөрлөлийн тоо Ойн мэргэжлийн байгууллагын тоо	0	1	3	4	АЗДТГазар	БОАЖГ, СДОА
1.9	2023-2030 он хүртэл мод тарих, ойн зурвас байгуулах талбайг үе шаттай төлөвлөх, Газар зохион байгууллалтын тусган төлөвлөгөөнд тусган батлуулах	га	2553		65000		АЗДТГазар, ГХБХБГазар, Сумдын ЗДТГ	БОАЖГ, СДОА
1.10	"Хашаандаа амьдрай" аяныг өрнүүлж, дэд бүтцээр хангах, ашигт ургамал тарихыг бодлогоор Дэмжинэ	Дэмжих өрхийн тоо	0		100		АЗДТГ	БОАЖГ, СДОА ААН, байгууллагууд
1.11	Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэдэг их дээд, сургуулиудтай хамтран ажиллах	Суралцагчийн тоо	4	6	8	10	АЗДТГ	Их дээд сургуулиуд, коллеж
1.12	Гадаад хамтын ажиллагаа өргөжүүлэх						АЗДТГ	
1.13	Говь-тус хөтөлбөрийг хэрэгжүүлж, Улаан нуур-Даланзадгад-Тавантолгой чиглэлийн ус дамжуулах байгууламжийн ТЭЗҮ болон Даланзадгад сумын шинэ цэвэрлэх байгууламжийн саарал усыг ойжуулалт газар тариаланд ашиглах ажлын зураг төсвийг боловсруулах	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	30		100		АЗДТГ, БОАЖГ	Сав газрын захиргаадууд

1.14	Баянзагийн таримал заган ойн зурвас талбайн менежментийг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	44	100	150	200	АЗДТГ, БОАЖГ, СДОА	Аж ахуйн нэгж байгууллагууд
<b>Зорилт 2: Үр болон тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх</b>								
2.1	Байгалийн болон таримал ойн сангийн талбайгаас мод сөөгний үр, мөчир бэлтгэх, нөөц бий болгох	Үр /кг/	8.0 мянга	500.0 мянга	2.0 сая	5.0 сая	СДОА	Иргэд, нөхөрлөл ААН, байгууллагууд
2.2	Орон нутгийн мод үржүүлгийн газруудыг дэмжих, шинээр байгуулах,	Мод үржүүлгийн газрын тоо	7	15			АЗДТГ, БОАЖГ, СДОА	Иргэд, нөхөрлөл ААН, байгууллагууд
2.3	Мод үржүүлгийн газрын үр, тарьц суулгацын мэдээг нэгтгэн мэдээллийн сан бий болгох, олон нийтэд мэдээллэх	Мэдээний тоо	1	8			БОАЖГ	СДОА, Сумд
<b>Зорилт 3: Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбай нэмэгдүүлэх, ойжуулалт, ойн зурвас байгуулах, арчлан ургуулах ажлыг зохион байгуулах</b>								
3.1	Төв суурин газарт нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх	га	314.8	80			АЗДТГ, БОАЖГ	Сумд
3.2	Байгалийн заган ойн сэргэн ургалтыг дэмжих, ойжуулах	га	16	5200			БОАЖГ, СДОА	Иргэд, нөхөрлөл ААН, байгууллагууд
3.3	Хамгаалалтын ойн зурвасыг байгуулах, агро ойн аж ахуйг хөгжүүлэх	га	2553	65000			БОАЖЯ, АЗДТГ, БОАЖГ, СДОА	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт
3.4	Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	1	16			БОАЖЯ, АЗДТГ, БОАЖГ, СДОА	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд олон нийт
3.5	Байгалийн болон таримал ойн зурвасууд, нийтийн						БОАЖЯ, ОСХТ, БОАЖГ, СДОА	Мэргэжлийн тусгай

	зэмшлийн байгууламжид шавьжийн судалгаа, тэмцлийн ажлыг зохион байгуулах	ногоон хортон судалгаа, ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	1	8	зөвшөөрөлтэй байгууллагууд болон бусад аж ахуйн нэгж байгууллага
3.6	Ойжуулалт, ойн зурвас талбайн цаашдын арчилгаа хамгаалалт, хөгжүүлэлтийг иргэд, олон нийтийн сайн дурын бүлэг, хоршоолол, нөхөрлөлүүдэд хариуцуулах, дэмжих	Талбайн хэмжээ /га/	2553	65.0 мянга	БОАЖЯ, ОСХТ УТУГ, БОАЖГ, СДОА	Иргэд, олон нийтийн сайн дурын бүлэг, хоршоолол, нөхөрлөл, мэргэжлийн байгууллага
<b>Зорилт 4: Дэвшилтэд технологийг, техник багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийг бий болгох</b>						
4.1	Ургамлын эд, эсийн өсгөврийн лаборатори байгуулах					ААН, байгууллага
4.2	Хөрсний лабораторийн дээжийн тоног төхөөрөмжөөр хангах					МХГ
4.3	Бордооны үйлдвэр байгуулах					ААН, байгууллага
4.4	Бортогоны үйлдвэрийг байгуулах					ААН, байгууллага
4.5	Ногоон байгууламжийн худаг, уст цэгийн тоог нэмэгдүүлж усалгааны систем, холбогдох тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн засварлах, нэмэгдүүлэх	Талбайн хэмжээ /га/	524	10.0 мянга	АЗДТГ, БОАЖГ	СДОА, Сумд, аж ахуйн нэгж байгууллагууд
4.6	Олон наст модлог ургамлын хэрэглээг зогсоож, орлох түлшний үйлдвэрлэлийг байгуулж хэрэглээг эрчимжүүлнэ.	Үйлдвэрийн тоо	0	1	АЗДТГ, БОАЖГ	ААН, байгууллага

4.7	Усыг хэмнэлттэй ашиглах төлөвшлийг бий болгож, дэвшилтэд технологийн усалгааны системийг нэвтрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	0	3	АЗДТГ, БОАЖГ	ААН, байгууллага
<b>Зорилт 5: Сургалт, сурталчилгаа зохион байгуулах</b>						
5.1	Мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах сургалтад хамрагдах	Сургалтын тоо	4	8	АЗДТГ Их дээд сургуулиуд	БОАЖГ СДОА
5.2	Нөхөрлөл, Аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил, аргазүйгээр хангах сургалт зохион байгуулах	Суралцагчийн тоо /хүн/	100	2.4 мянга	АЗДТГ, БОАЖГ, СДОА	Мэргэжлийн байгууллага
5.3	СДОА-нгийн ойжуулалтын сургалтын төвийг говийн бүсийн ойжуулалтын сургалтын төв болгож өргөжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр			АЗДТГ, БОАЖГ, СДОА	СДОА, Мэргэжлийн байгууллага
5.4	Туршлага судлах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	АЗДТГ	БОАЖГ
<b>Зорилт 6: Санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох</b>						
6.1	Нэгдсэн сан байгуулах					
6.2	Олон улсын болон орон нутгийн төсөв					
6.3	Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт					
6.4	Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө					
6.5	Бусад эх үүсвэр					